



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 9/186

Мандалговь

Г Дархлаажуулалтын 10 хоногийн аян  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн "Дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулах тухай" А/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийн аяны үйл ажиллагааг 2019 оны 5 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд "Улаанбурхан өвчинд цэг тавъя" уриан дор зохион байгуулсугай.

Хоёр. Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд зорилтот 10-18 насны хүүхдүүдийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар нэмэлт дархлаажуулалтанд хамруулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн зохион байгууллаар зохион байгуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, дархлаажуулалтанд шаардлагатай вакцин биобэлдмэл, гарын авлагаар эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Г.Бат-Орших)-д, зорилтот насны хүүхдүүдийг аюулгүй дархлаажуулж ажиллахыг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт тус тус даалгасугай.

Гурав. Дархлаажуулалтын 10 хоногийн аяны хүрээнд орон нутгийн хэмжээнд зорилтот 10-18 насны хүүхдүүдийг улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд 100 хувь хамруулах арга хэмжээг ажлын хэсэг гарган зохион байгуулж, шаардлагатай шатахуунаар хангах, улаанбурхан, улаанууд өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллах, эцэг, эх асран хамгаалагчдад таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хамрагдалтанд хяналт тавьж, хамрагдалтын мэдээг тухай бүр Эрүүл мэндийн газарт мэдээлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвд суралцаж буй зорилтот насны сурагчдыг хамруулах ажлыг харьяа эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж, "Явуулын цэг"-ээр ажиллах эмч, мэргэжилтнүүдийг ажиллах байр, нөхцлөөр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга (Ц.Бумангэрэл), ерөнхий боловсролын сургуулиудын захирад наарт тус тус үүрэг болгосугай.

Тав. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Наантuya)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ 488190568